



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

139 /139/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.09.21

## АРТИЛЛЕРИ, ЗЭВСГИЙН ТЭНХИМИЙН 100 ЖИЛ ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!

Түүхэнд энэ өдөр

### МЭНДЧИЛГЭЭ



Одоогоос 100 жилийн тэртээ жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар "Их даргын сургууль" байгуулж анхны 3 мэргэжлийн нэг их бууны мэргэжилтэнг 1921 оны 10 дугаар сарын сарын 15-ны өдрөөс зургаан сарын хугацаатай 20 хүнийг бэлтгэснээр артиллерийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн түүх эхэлдэг юм.

Энэ л өдрөөс хойш ҮБХИС-ийн Артиллери, Зэвсгийн тэнхим Монгол Улсын Зэвсэгт хүчинд олон зуун мэргэжилтэн бэлтгэхийн сацуу тус төгсөгчдөөс Улс эх орон, Батлан хамгаалах салбаруудад үр бүтээлтэй ажиллаж байна.

Ингээд Артиллери, Зэвсгийн тэнхимийн үе үеийн төгсөгчид, эрдэмтэн багш, сонсогч, ажилтан алба хаагч нартаа Артиллери, Зэвсгийн тэнхимийн түүхт 100 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, ажил албаны арвин их амжилт, амьдрал тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

Эрхэм хүндэт Артиллери, Зэвсгийн тэнхимийн үе үеийн төгсөгчид, эрдэмтэн багш нартаа Артиллери, Зэвсгийн тэнхимийн түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

АРТИЛЛЕРЧДИЙН ЯРУУ АЛДАР, СҮЛД ХИЙМОРЬ ҮЕИЙН ҮЕД МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ!

ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн артиллери, зэвсгийн тэнхимийн дарга, хурандаа Ц.ЦЭРЭНБАТ

### Эрхэм зорилго:

Монгол Улсын үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдэлдэг, захиалагч байгууллагын эрэлт хэрэгцээг хангасан мэдлэг, ур чадвар, ёс зүйн зөв төлөвшил, хандлагатай, томилогдсон албан тушаалдаа мэргэжлийн өндөр түвшинд ажиллах чадвартай артиллерийн болон зэвсгийн албаны бакалаврын боловсролтой офицер, мэргэжлийн ахлагчийг бэлтгэхэд оршино.

### Зорилт:

- 1.Тэнхимийн сургалтын хөтөлбөрийг тодотгон шинэчлэн, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах, бакалаврын боловсролын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлүүлэх
- 2.Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг төгөлдөржүүлж, инновацыг нэвтрүүлэх
- 3.Мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
- 4.Багш нарын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар тэдний чадавхыг нэмэгдүүлэх
- 5.Суралцагчдын суралцах үйл ажиллагааг дэмжих, сургалтын орчин, нөхцөлийг шинэчлэн, сайжруулах
- 6.Тэнхимийн багш, суралцагчдын ёс зүй, цэргийн алба, сахилга, хариуцлагыг сайжруулах

### ТҮҮХЭН ЗАМНАЛ

1921 онд Д.Сүхбаатарын санаачилга, "Цэргийн зөвлөл"-ийн шийдвэрээр "Ардын цэргийн даргын сургууль"-ийг /зарим түүхийн номд "Их даргын сургууль"/ 1921 оны 9 дүгээр сард байгуулж, морин цэргийн тасаг-2, суралцагч-40 хүнтэй, артиллерийн тасаг-1 суралцагч-20 хүнтэй, морьт пулемётын тасаг-1 суралцагч-30 хүнтэйгээр зохион байгуулалт, бэлтгэлийг хангаад 1921 оны 10 дугаар сарын 15-д анхны хичээлийг зааснаар Монгол Улсад үндэсний артиллерийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн, "Артиллери, Зэвсгийн тэнхим" үүсэн байгуулагдсан өдөр болгон түүхэнд тэмдэглэсэн юм.

1922-1923 оны хичээлийн жилээс "Их даргын сургууль"-д артиллерийн ангийг нэмж 1 жилийн хугацаатай мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн юм. Монгол Ардын Засгийн Газрын гишүүдийн 1923 оны 7 дугаар хурлаар "Их даргын сургууль"-ийг шинэчлэн байгуулах тухай түр дүрмийг хэлэлцэн баталж, артиллерийн ангийн суралцах хугацааг гурван жил болгон шинэчилсэн. Улмаар 1964 онд Цэргийн ерөнхий сургуулийг өргөтгөн байгуулахад бүтцэд "Артиллерийн секц" нэмэгдэн сургалтын үйл ажиллагаа өргөжсөн. Батлан хамгаалах сайдын 1967 оны 28 тоот тушаалаар ЦЭС-ийн "Артиллерийн секц"-ийг ЦЕДС-ийн "Артиллерийн тэнхим" /кафедр/ болгон өргөтгөсөн байна.

1991 онд Цэргийн нэгдсэн дээд сургууль Цэргийн их сургууль болоход шинээр 2 тэнхим байгуулагдсаны нэг нь "Зэвсгийн тэнхим" юм.

Тус тэнхим шаталсан сургалт явуулах шийдвэрийн дагуу шинээр сургалтын төлөвлөгөө, 3 жилийн "Зэвсгийн техникч" мэргэжлийн, 4 жилийн "Зэвсгийн ашиглалтын инженер" мэргэжлийн хичээлийн хөтөлбөр боловсруулж, сургалтыг тасралтгүй чанартай зохион байгуулж ирсэн.

1997 онд "Зэвсгийн тэнхим"-ийг "Артиллерийн тэнхим"-тэй нэгтгэж "Артиллери, Зэвсгийн тэнхим"-ийг байгуулсан түүхтэй. Тэнхим байгуулагдан "Артиллерийн командны офицер-төрийн захиргааны ажилтан", "Цэргийн зэвсгийн алба-төрийн захиргааны ажилтан", 2008 оноос "Артиллерийн команд-инженер математик", Цэргийн зэвсгийн алба-инженер математик", 2014 оноос "Артиллерийн команд-хэрэглээний математик", "Цэргийн зэвсгэл-хэрэглээний математик" мэргэжлээр бакалаврын боловсролтой офицер бэлтгэсэн байна. 1998-2018 оны

хичээлийн жилд Артиллери, Зэвсгийн тэнхимийн 330 гаруй сонсогч/давхардсан тоогоор/ анги дэвших шалгалтад орж, 96-99,3 хувийн амжилт үзүүлж суралцсан байна.

2015 онд БХИС-ийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөхөд "Артиллери, Зэвсгийн тэнхим"-ийг задалж Хуурай замын цэргийн тэнхимийн бүрэлдэхүүнд артиллерийн багш нарыг мэргэжлийн профессорын баг болгон нэгтгэж, зэвсгийн мэргэжилтэн бэлтгэхээр Зэвсгэл, галт хэрэглээний тэнхимийг шинээр байгуулсан юм.

Батлан хамгаалахын сайдын 2017 оны 152 дугаар тоот тушаалаар ҮБХИС-ийн бүтэц шинэчлэгдэж "Артиллери, Зэвсэг"-ийн тэнхим дахин байгуулагдаж, сургалтын үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Артиллери, Зэвсгийн тэнхим нь одоогоор "Артиллери" бакалаврын боловсролын хөтөлбөрөөр "Артиллерийн командын офицер", "Цэргийн зэвсгэл" бакалаврын боловсролын хөтөлбөрөөр "Зэвсгийн албаны офицер" мэргэжлээр офицер, мэргэжил олгох сургалтын хөтөлбөрөөр "Артиллерийн бууны наводчик", "Артиллерийн тагнуулчин, гал засварлагч", "Зэвсгийн нярав, засварчин" мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэж байна.

Үүссэн цагаас өнөөг хүртэлх 100 жилийн хугацаанд артиллерийн мэргэжлээр даргалах дунд боловсролтой 755, ерөнхий эрдмийн дээд боловсролтой-134, артиллерийн инженерийн дээд боловсролтой 408 нийт 1300 гаруй, зэвсгийн мэргэжлээр даргалах дээд боловсролтой зэвсгийн ашиглалтын инженер мэргэжилтэй-12, зэвсгийн алба-төрийн захиргааны удирдлагын мэргэжилтэй-58, зэвсгийн алба-математикч мэргэжилтэй-27, зэвсгийн албаны офицер мэргэжилтэй-9, цэргийн зэвсгэл мэргэжилтэй-5 нийт 121, тусгай дунд боловсролтой зэвсгийн нярав, засварчин мэргэжилтэй-760 нийт 891 гаруй боловсон хүчнийг бэлтгэн гаргаад байна.

2014 он хүртэл D860300-01 индексээр сургалтыг явуулж байсан бөгөөд 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар D103102 индекс рүү шилжин сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан ба Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 09 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн нь Монгол Улсад анх удаа цэргийн мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн түүхэн явдал байв.

1965 он:

З Х У - а а с  
БНМАУ-ын армийг техникээр хангахад зориулан БНМАУ-д үзүүлэх талаарх хэлэлцээрт хоёр орны төлөөлөгчид гарын үсэг зурав

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,847.00	2,851.00
EUR	3,340.0	3,360.0
CNY	440.05	441.07
RUB	38.20	39.40
JPY	25.76	26.26
KRW	2.36	2.49

### ЗУРХАЙ

2021.09.21 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН МОГОЙГ ХҮЛЭГЧ ОДТОЙ, ХАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингих:

06.38-18.53

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Өтлөх төрөхүй

Суудал:

Гал

Ардын тооллын 9 сарын 21, Ангараг гараг. Билгийн тооллын 16, Могойг хүлэгч одтой, хар бич өдөр. Өдрийн наран 6 цаг 38 минутад мандан, 18 цаг 53 минутад жаргана.

Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адуус муулах, сүм дуганыг сэргээх, бужиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### БИДНИЙ АМЖИЛТААС...

1. 1996 онд ЦИС-ийн тэргүүний тэнхим;
2. 1997 онд тэргүүний тэнхим;
3. 2007, 2008, 2012 онд БХИС-ийн тэргүүний тэнхим;
4. 2013 онд тэргүүний тэнхимийн "Дэд байр";
5. 2018, 2019 онд ЦНС-ийн тэргүүний тэнхим;
6. 2015 онд багш, хошууч Б.Мандахбаяр БХИС-ийн тэргүүний багш;
7. 2015 онд дадлагын багш, сургагч ахлагч Б.Мөнх-Эрдэнэ БХИС-ийн тэргүүний дадлагын багшаар шалгарсан.
8. 2016 онд тэнхимийн дарга, хурандаа И.Батсайхан "Цэргийн ухааны доктор (Ph.D)"-ын зэрэг хамгаалсан.
9. 2016 онд багш, дэслэгч Б.Батбаяр БХИС-ийн тэргүүний залуу багшийн "Дэд байр"
10. 2017 онд багш, ахлах дэслэгч Б.Батбаяр ҮБХИС-ийн тэргүүний залуу багш;
11. 2018 онд багш, доктор (Ph.D), дэд хурандаа Д.Содномцог ҮБХИС-ийн тэргүүний судлаач багшаар тус тус шалгарсан.
12. 2018 онд багш, ахлах дэслэгч С.Мөнхсаруул ҮБХИС-ийн тэргүүний багшийн "Дэд байр"
13. 2018 онд багш, ахлах дэслэгч Б.Батбаяр, С.Мөнхсаруул нарын "Галт хэрэглэл" хөтөч сурах бичиг ҮБХИС-ийн шилдэг сурах бичиг
14. 2019 онд багш, ахлах дэслэгч Б.Батбаяр ҮБХИС-ийн тэргүүний багшийн "Гутгаар байр"
15. 2019 онд сургагч багш, ахлах ахлагч Э.Энхтайван ҮБХИС-ийн тэргүүний сургагч багшийн "Дэд байр"
16. 2019 онд багш, ахлах дэслэгч Б.Батбаяр "Цэргийн ухааны доктор (Ph.D)"-ын зэрэг хамгаалсан.
17. 2021 онд багш, ахмад Б.Лхагважав ҮБХИС-ийн шилдэг инновацын бүтээлийн "Тэргүүн байр"-ыг эзэлсэн.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 247,212 +2851	ЭДГЭРСЭН 241,501 +5211	НАС БАРСАН 1042 +8
-----------------------------------	---------------------------	-----------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5051 +86	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 200	ЭДГЭРСЭН 4755
-----------------------------	----------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 229,761,465
Эдгэрсэн Нийт: 206,414,011
Нас барсан Нийт: 4,711,677



Артиллерия, Зэвсгийн Тэнхимийн Хамт Олон



Зүүн гар талаас: Артиллерийн багш, ахмад Б.Лхагважав, артиллерийн ахлах багш, дэд хурандаа А.Нямхүү, тэнхимийн дарга, хурандаа Ц.Цэрэнбат, зэвсгийн багш ахмад С.Мөнхсаруул, артиллерийн багш, хошууч Б.Бат-Эрдэнэ

Артиллерия бол байнгын дадлага шаардана гэсэн уриатай ажиллаж байсан үе минь



Боржигон овогт Гомбо миний бие Архангай аймгийн Өгийнуур сумын Чулуут нуурын хөвөөнд 1943 оны усан хонин жил малчин ард Вандангийн гуравдугаар хүү болж төрсөн. 1953-1959 онд Ерөнхий боловсролын дунд сургуульд суралцаж төгссөн ба 1960 онд Санхүү-эдийн засгийн техникумд элсэн суралцсан.

Улмаар 1963 онд цэргийн албанд татагдан ирж, мөн ондоо ЗХУ-ын Тбилис хотноо Артиллерийн командын сургуульд журмын нөхөд Ж.Хүрэлжанцан, З.Даш-Очир, Л.Тогтох нарын хамт суралцаж, цахилгаан тоног төхөөрөмжийн механик мэргэжлээр 1966 онд төгссөн. Ингэснээр Зэвсэгт хүчний 019 дүгээр ангид Галт салааны даргаар томилогдон ажилласан.

1967 онд Цэргийн ерөнхий сургуульд багшаар томилогдон сургуулийн захирал, хошууч генерал Д.Дамдинхүүд илтгэснээр миний амьдралын түүх энэ л сургуультай холбогдсон юм. 1972-1976 онд ЗХУ-ын Ленинград хотод Артиллерийн командын академид суралцаж, Газрын артиллерийн команд штабын дээд боловсролыг эзэмшсэн.

1976 оноос 019 дүгээр ангийн штабын даргаар ажиллаж байгаад 1977 оны 8 дугаар сард ЦЕДС-ийн Артиллерийн кафедрт ахлах багшаар дахин томилогдож, артиллерийн тагнуул, байр зүй, геодезийн бэлтгэл, байлдааны албаны хичээлүүдийг зааж байсан. Тухайн цаг үед сургалтын агуулгыг шинэчлэх, заах арга зүй, үр чадварыг дээшлүүлэх зэрэг олон төрлийн шат дараалсан шаардлагууд тавигддаг байв. Миний хувьд шинээр санаачлан сургалтад ашиглаж байсан зүйлүүдийн заримаас дурдвал:

-Тагнуул, солбисон хяналтын хээрийн хэмжилтийн үр дүнг боловсруулах гарын авлага, сэдвийн боловсруулалт, үзүүлэн таниулах материал, сургалтын техник хэрэгслийг тухайн шаардлагад зохицуулан хэрэглэсэн.

Байлдааны буудлагатай хээрийн сургуулийн үед галт, хянах байрууд болон цөлүүдийн солбицол, холын

зай, өнцгийг өндөр нарийвчлалтай тодорхойлохын тулд сонсогчидтой хамтран ажиллаж байсан нь байлдааны буудлагыг цаг хугацаанд нь сум, галт хэрэглэлийн хэмнэлттэй, нарийвчлал сайтай явуулахад ихээхэн үр нөлөөтэй байв.

Холболт муу бол буудлага муу, артиллери бол байнгын дадлага шаардана гэсэн уриатай бид ажиллаж байлаа.

Багш нарын үр ухаан, хүч хөдөлмөрөөр танхимын болон хээрийн нөхцөлд том, жижиг (винтов, хийн бууны) полигонууд, байр зүй, геодезийн тулгуурт цэгүүдийг байгуулж, тэдгээрийг сургалт, дадлагад ашигладаг байсан нь онолын мэдлэгийг бататгах дадлагад сургахад үр дүнтэй болдог байв.

Би тухайн үед цэргийн хэргийн эрдэм, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт аргуудыг сургалтад ашиглах, сонсогчдод эзэмшүүлэхийн төлөө өөрийн мэдлэг, үр чадвараа дайчлан, тэдэнтэй нэг бүрчлэн эсвэл хэсэг бүлгээр нь ажилладаг байсан нь сургалтын хоцрогдлыг арилгахад тус дөхөм болдог байв.

Жавар тачигнасан хүйтний улиралд хээрийн нөхцөлд дадлага сургууль хийх нь олонтоо тохиолдоно. Заримдаа сонсогчдын идэвх сулрах, өөр хоорондоо ноцолдох, сахилгагүйтэх тохиолдол гардаг байсныг нуух юун. Энэ үед тэднийг ойролцоо довтог, толгод дээр гарган хэсэгхэн хугацаагаар салхи сөргүүлэн зогсоож, намайг малгай буулгаагүй цагт та нар малгай буулгахгүй шүү гэж үүрэгдэн тэсвэр хатуужлыг нь шалгадаг байв. Энэ үед заримынх нь чих, хамар хайрагдах, хөлдөх тохиолдол гардаг байсныг офицер болсон хойноо дурсан ярьж, намайг "яс хүн" хэмээн нэрлэдэг байсныг нь тэднээс сонсож билээ.

Миний бие 1980 онд МУИС-ийн дэргэдэх Сурган хүмүүжүүлэх ухааны дамжаанд, 1984 онд ЗХУ-ын Солнечногорск хотод Буудлага, тактикийн мэргэжил дээшлүүлэх дамжаанд тус тус суралцан, багшлах үр чадвараа дээшлүүлж байлаа.

Алдар гавьяатай энэ сургуульд ардын хүүхдийг артиллерийн мэргэжлээр сурган хүмүүжүүлэх их үйлсэд 18 жил хөдөлмөрлөж, биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан 1989 онд гавьяаныхаа амралтад гарсан юм.

Дээрх хугацаанд кафедрын

дарга Л.Рэнчиндорж, Д.Цэен, Ж.Мэндбаяр нарынхаа удирдлагад гар нийлэн ажиллаж, армийн аль ч хэсэгт артиллеричид манлайлдаг сайхан уламжлалыг нь нэр төртэй үргэлжлүүлэн хөгжүүлж, сургуулийн хэмжээнд шилдэг тэргүүний кафедраар олон удаа шалгарсан юм. Дээр дурдсан олон дарга, багш нарын дотроос хамгийн олон жил удирдлагад нь байж, хамтран ажилласан хүн бол Д.Цэен дарга минь байлаа. Бид хамтдаа тус кафедрт 16 жил ажилласан. Миний дарга цэргийн хэргийн эрдэм, боловсрол сайтай, аливаа ахүнд зарчимч шаардлага тавьдаг, хэлэх зүйлээ шулуухан хэлдэг, дутагдлын хажуугаар дуугүй өнгөрдөггүй, аливаа ажлыг эхлүүлсэн бол дуусгаж байж санаа нь амардаг хөдөлмөрч хүн байсан даа. Надтай хамт мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэхэд хамтран ажиллаж байсан олон арван багш нар бий. Тухайлбал: Дэнзэн, Сандаг, Гаанжуур, З.Даш-Очир, О.Уржин, Д.Базарсад, Б.Өлзийбаяр, Пүрэвдорж, Пүрэвзав, Сосорбарам гээд өөр өөрийн заах аргын онцлогтой олон тэргүүний багш нарыг дурдаж болно. Би зөвхөн багш нарын зарим төлөөллийг нэрлэж, олон тэргүүний багш нарыг орхигдуулсан байж болзошгүй тул хүлцэл өчье.

Би 1979-1988 онд Дээд боловсролын хорооны томилолтоор дотоод, гадаадын их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын гишүүнээр (Баян-Өлгий, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд) аймгуудад ажиллаж, цэрэг армид хүчин зүтгэх чин эрмэлзэлтэй, сонирхолтой хөвгүүдтэй уулзан ярилцаж, арми, сургуулийнхаа амьдрал, түүхийг сурталчлан мэргэжлийн төрөл, тэдгээрийн онцлогийг ухуулан таниулж ойлгуулсны үндсэн дээр ЦЕДС-д сурагчдыг сонирхлынх нь дагуу тухайн мэргэжилд нь сонгон шалгаруулж, томилолт бичүүлж, элсүүлж явлаа. Тэдгээр залуус сонгосон мэргэжлээ чадварлаг эзэмшин, сургуулиа амжилттай төгсөөд манай орны өнцөг, булан бүрд алдар цуугаа мандуулан үр бүтээлтэй ажилласаар байна.

Их жанжны нэрэмжит алдар гавьяатай энэ их сургууль нь цэрэг армийн төдийгүй улс эх орондоо олон арван шилдэг тэргүүний боловсон хүчин бэлтгэж, эх орноо хамгаалах, олон улсын энхийг сахиулах, бүтээн байгуулах үйл хэрэгт асар их хувь нэмэр оруулсны дотор миний олон арван шавь нар ч төр, засаг, түмэн олондоо үнэлэгдэн алдар нэрээ дуурсгаж явна. Заримаас нь дурдвал, доктор профессор, хошууч генерал О.Уржин, УИХ-ын гишүүн Х.Жекей, бригадын генерал Н.Энхбаялаг, Ж.Бадамбазар, хурандаа Доржханд, Төмөр, Анод банкны Даваа, бэлтгэл хурандаа доктор, профессор Х.Шагдар, П.Алгаа, Б.Цэрэндашдорж, Ж.Мэндбаяр нарын олон арван оюунлаг шавь нараа бахархан санаж явдаг. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

Чөлөөнд байгаа дэд хурандаа Вандангийн ГОМБО

Артиллерия, Зэвсгийн Тэнхимээс Төрсөн Алдартнууд



МУ-ын баатар Л.Гэлзгбаатар /1938 оны төгсөгч/



Хошууч генерал Д.Цолмон /1926 оны төгсөгч/



Хошууч генерал Г.Эрэндоо /1927 оны төгсөгч/

ГЕНЕРАЛУУД

1. Хурандаа генерал С.Лувсангомбо /1953-1956 онд зэвсгийн багш/
2. Дэслэгч генерал Ч.Пүрэвдорж /1955 оны төгсөгч/
3. Хошууч генерал Г.Эрэндоо /1927 оны төгсөгч/
4. Хошууч генерал Д.Гэндэнпил /1955 оны төгсөгч/
5. Хошууч генерал Г.Түмээ /1953-1956 онд тэнхимийн дарга/
6. Хошууч генерал Г.Дугарсүрэн /1956 оны төгсөгч/
7. Хошууч генерал О.Уржин /1975 оны төгсөгч, 1981-1988 онд багш, 1992-1995 онд тэнхимийн дарга/
8. Хошууч генерал Б.Баярмагнай /1994 оны төгсөгч, дамжааны багш/
9. Хошууч генерал Ж.Бадамбазар /1984 оны төгсөгч, 1994-1997 онд багш/
10. Бригадын генерал Н.Энхбаялаг /1978 оны төгсөгч, 1979-1984 онд курс, батареины захирагч/
11. Бригадын генерал Д.Баярсайхан /1992-1994 онд зэвсгийн багш/
12. Бригадын генерал Л.Гансэлэм /1995 оны төгсөгч/
13. Бригадын генерал Ц.Гандорж /1994 оны төгсөгч/

ДОКТОРУУД

1. Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хошууч генерал О.Уржин /1975 оны төгсөгч/
2. Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хурандаа Х.Шагдар /1973 оны төгсөгч/
3. Түүхийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Б.Товд /1951-1956 онд багш/
4. Техникийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Цэен /1969-1973, 1976-1985 онд тэнхимийн дарга/
5. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Лхагвасүрэн /1977 оны төгсөгч, 1989-2003, 2005-2013 онд багш /
6. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Н.Түүхбаатар /1975 оны төгсөгч/
7. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа П.Алгаа /1975 оны төгсөгч/
8. Цэргийн ухааны доктор (Ph.D), профессор, хурандаа А.Хүү-Ухнаа /1992-1994 онд анхны зэвсгийн тэнхимийн дарга/
9. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Я.Мягмарсүрэн /1968 оны төгсөгч/
10. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа З.Жамьянчагнаа /2000-2011 онд зэвсгийн багш, ахлах багш/
11. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор, хурандаа И.Батсайхан /1991 оны төгсөгч, 2010-2013, 2015-2019 онд тэнхимийн дарга/
12. Цэргийн ухааны доктор (Ph.D), хурандаа Д.Содномцог /1994 оны төгсөгч, 2017-2018 онд артиллерийн багш/
13. Цэргийн ухааны доктор (Ph.D), бригадын генерал Ц.Гандорж /1994 оны төгсөгч/
14. Цэргийн ухааны доктор (Ph.D), дэд хурандаа Б.Мандахбаяр /2002 оны төгсөгч, 2008-2015 онд артиллерийн багш/
15. Цэргийн ухааны доктор (Ph.D), ахмад Б.Батбаяр /2003 оны төгсөгч, 2014 оноос зэвсгийн багш/



Артиллерия, Зэвсгийн Тэнхим нь түүхт 100 жилийн ойг угтаж...



1. "Артиллерийн цахим сургалтын технологи-КХБ" төслийн хүрээнд 203 дугаар танхимыг тохижуулах /Төслийн удирдагч, доктор Ph.D, хурандаа Д.Содномцог/
2. "Артиллери, зенитийн зэвсэглэлийн гол төмөрт үзлэг хийх багаж" төсөлт ажил хэрэгжүүлэх /Төслийн удирдагч, доктор Ph.D, дэд профессор, хурандаа И.Батсайхан/
3. УБХИС-ийн Шархад хээрийн сургалтын төвд "Артиллерийн сургалтын хотон" байгуулах
4. Тэнхимийн түүхэн замналаар "Артиллери, Зэвсгийн

- тэнхим-100 жил" ном гаргах
5. "Буудлагын зэвсэглэлийн виртуал танхим" байгуулж, нэрэмжит болгох
  6. "Буудлагын зэвсэглэл" хөтөч сурах бичиг гаргах
  7. "Артиллерийн бууны захирагч, тоотуудын ажиллагаа" ном гаргах
  8. "122 мм-ийн Гаубиц М-30" номыг шинэчлэн гаргах
  9. "Артиллери", "Цэргийн зэвсэглэл"-ийн магистрын болон 4 жилийн бакалаврын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулах
  10. Тэнхимийн 100 жилийн ойн тэмдэг, дурсгалын медальон гаргах
  11. Тэнхимийн лого болон УБХИС-ийн цахим хуудсанд байрлах танилцуулгыг шинэчлэх
  12. Артиллерийн зэвсэглэлийн дадлагын байрыг тохижуулах
  13. Ахмад болон залуу багшийн төлөөлөл, тэнхимийн үйл ажиллагааг сурталчлах.